



ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Захирамжийн хавсралтад
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7.1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагчийн Үйлчилгээний хөлс, төлбөр, хураамж тогтоох тухай 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/72 тоот захирамжийн хавсралтаар батлагдсан “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанаас үзүүлэх үйлчилгээний хөлс, төлбөр, хураамжийн хэмжээний 3.8 дахь хэсгийг нэгдүгээр хавсралтаар өөрчлөлт оруулсугай.

2. Мөн “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанаас үзүүлэх үйлчилгээний хөлс, төлбөр, хураамжийн хэмжээний 3.13 болон 3.14 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнэт цаас, эх бэлтгэл, хэвлэлтийн үйлчилгээ үзүүлсний төлбөрийг 10 000 төгрөгөөр тогтоосугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтэс /Ч.Баттулга/, Бүртгэл санхүүгийн хэлтэс /Ж.Баатарсүрэн/ -т тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн Ажлын алба /М.Энхбаяр/-нд үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



И.БАТНАСАН

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн
2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
А/29 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНААС ҮЗҮҮЛЭХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС, ТӨЛБӨР, ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

3.8	Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох	<p>Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгох – 1 000 000 Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах – 1 000 000</p> <p>Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгох – 300 000 Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах – 300 000</p> <p>Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох – 1 500 000 Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах – 1 500 000</p> <p>Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох – 750 000 Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах – 750 000</p>
-----	---	---